

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/67/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Х.Еркебулан Утас: 92921881 Цахим хаяг: erkebulankh@ audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт.....	19
Байхгүй	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ДЭЛҮҮН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.НУРХУАТ
ТАНАА

2022.02.05 № 308
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн дансанд 1,579.7 сая төгрөгийн, бараа материалын дансанд 50.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийхдээ 248.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу тоолсон, тооллогын бүртгэлийн дүнгүүд нь зөрүүтэй, 50.2 сая төгрөгийн бараа материалын тооллого хийгдээгүй, тооллогын дүнг санхүүгийн тайлан дахь хөрөнгийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй.

2. Санхүүгийн тайлангаар 23.8 сая төгрөг гарснаар тайлагнасан боловч 17.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлийг баталгаажуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 14 дүгээр зүйлийн 14.3, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>42179231.88</u>	<u>50201063.88</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	284900.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	284900.00	0.00
3121	Төгрөг	284900.00	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	284900.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	41894331.88	50201063.88
351	Түүхий эд материал	7842810.00	9370470.00
35130	Эм боох материал	7842810.00	9370470.00
354	Хангамжийн материал	34051521.88	40830593.88
35410	Бичиг хэргийн материал	440000.00	0.00
35420	Аж ахуйн материал	29017206.88	32719803.88
35440	Түлш, шатах тослох материал	411400.00	0.00
35460	Хүнсний материал	3182915.00	7110790.00
35470	Бусад хангамжийн материал	1000000.00	1000000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1161844388.73</u>	<u>1400637266.07</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,161,844,388.73	1,400,637,266.07
392	Биет хөрөнгө	1,145,316,388.73	1,384,109,266.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,115,103,146.09	1,206,813,060.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(51,915,435.64)	(77,569,217.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	136,038,422.00	137,286,422.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(87,827,300.46)	(68,006,787.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	97,340,224.03	156,715,396.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	(67,424,668.13)	(26,960,808.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,918,114.00	61,870,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,941,113.16)	(6,063,799.08)
39217	Ном	25,000.00	25,000.00
393	Биет бус хөрөнгө	16,528,000.00	16,528,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,528,000.00	16,528,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,204,023,620.61</u>	<u>1,450,838,329.95</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>21035166.00</u>	<u>23834389.15</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21035166.00	23834389.15

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

413	Өглөг	21035166.00	23834389.15
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12974762.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6664500.00	22467961.15
4136	Бусад өглөг	1395904.00	1366428.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1395904.00	1366428.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1182988454.61	1427003940.80
51	Засгийн газрын хувь оролцоо	1182988454.61	1427003940.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	219336811.00	219336811.00
51101	Өмч: - төрийн	219336811.00	219336811.00
512	Хуримтлагдсан үр дүн	685,808,663.94	946,756,220.13
51210	Өмнөх үеийн үр дүн	729,897,622.90	702,740,733.94
51220	Тайлант үеийн үр дүн	(44,088,958.96)	244,015,486.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	277,842,979.67	260,910,909.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1204023620.61	1450838329.95

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	881,183,288.00	1,269,950,538.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,953,200.00	13,286,004.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,953,200.00	13,286,004.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,953,200.00	13,286,004.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,953,200.00	13,286,004.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	879,230,088.00	1,256,664,534.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	854,717,800.00	798,829,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	854,717,800.00	798,829,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	467,400.00	99,971,258.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	467,400.00	99,971,258.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,879,988.00	311,599,486.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	32,735,600.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	23,879,988.00	278,863,886.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	164,900.00	46,264,490.00

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	164,900.00	46,264,490.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	925,272,246.96	1,025,935,051.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	925,272,246.96	1,023,640,058.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	924,572,246.96	954,791,096.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	627,481,112.00	600,449,702.45
210101	Үндсэн цалин	540,785,017.00	383,377,376.00
210102	Нэмэгдэл	45,363,133.00	154,498,426.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,059,000.00	6,888,000.00
210104	Урамшуулал	37,273,962.00	55,685,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,479,050.00	90,476,843.55
210201	Тэтгэврийн даатгал	57,164,650.00	69,446,788.32
210202	Тэтгэмжийн даатгал	6,078,600.00	5,267,809.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,862,900.00	4,214,227.25
210204	Ажилгүйдлийн даатгал	1,215,700.00	1,391,176.40
210205	Эрүүл мэндийн даатгал	12,157,200.00	10,156,841.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,724,504.00	31,540,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,716,800.00	5,568,700.00
210302	Түлш, халаалт	32,166,304.00	25,972,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,841,400.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	34,958,771.12	69,973,606.00
210401	Бичиг хэрэг	1,306,030.00	4,788,628.00
210402	Тээвэр, шатахуун	30,427,345.00	50,866,468.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	175,200.00	1,400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	437,196.12	1,700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,613,000.00	5,027,500.00
210408	Бараа материал акталсны зардал	-	6,191,010.00
2105	Нормативт зардал	86,112,637.00	93,416,753.15
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	63,639,282.00	62,235,768.15
210502	Хоол, хүнс	18,803,755.00	24,680,985.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,669,600.00	6,500,000.00

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,177,300.00	10,156,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,426,000.00	7,750,300.00
210604	Урсгал засвар	1,751,300.00	2,406,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,980,000.00	5,741,058.00
210702	Дотоод албан томилолт	1,980,000.00	5,741,058.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,143,300.00	2,407,418.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	336,000.00	505,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,600.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,400.00	120,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	800,000.00
210807	Газрын төлбөр	120,800.00	114,168.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	200,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	445,500.00	445,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,515,572.84	50,628,115.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,608,105.00	1,779,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,907,467.84	48,849,015.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	700,000.00	68,848,962.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	700,000.00	68,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	68,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	48,962.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	48,962.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,294,992.92
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2,294,992.92
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	-	2,294,992.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(44,088,958.96)	244,015,486.19
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(44,088,958.96)	244,015,486.19

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	219,336,811.00	277,842,979.67	685,808,663.94	1,182,988,454.61
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	219,336,811.00	277,842,979.67	685,808,663.94	1,182,988,454.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			16,932,070.00	16,932,070.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	219,336,811.00	277,842,979.67	702,740,733.94	1,182,988,454.61
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-16,932,070.00		-16,932,070.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			244,015,486.19	244,015,486.19
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	219,336,811.00	260,910,909.67	946,756,220.13	1,427,003,940.80

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	855350100.00	977800648.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	855350100.00	977800648.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	854717800.00	798829300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	854717800.00	798829300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	467400.00	99971258.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	467400.00	99971258.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	32735600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		32735600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	164900.00	46264490.00

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	164900.00	46264490.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	855065200.00	967012548.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	855065200.00	967012548.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	854365200.00	898163586.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	613858100.00	613424464.45
210101	Үндсэн цалин	361163100.00	396352138.00
210102	Нэмэгдэл	188779500.00	154498426.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9741000.00	6888000.00
210104	Урамшуулал	54174500.00	55685900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82060900.00	90476843.55
210201	Тэтгэврийн даатгал	57746500.00	69446788.32
210202	Тэтгэмжийн даатгал	6078600.00	5267809.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	4862900.00	4214227.25
210204	Ажилгүйдлийн даатгал	1215700.00	1391176.40
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,803,000.00	31,129,300.00
210301	Гэрэл, цахилгаан	2,716,800.00	5,568,700.00
210302	Түлш, халаалт	31,244,800.00	25,560,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,841,400.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	41,451,400.00	55,020,702.00
210401	Бичиг хэрэг	1,245,500.00	4,450,000.00
210402	Тээвэр, шатахуун	36,282,200.00	42,670,702.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	175,200.00	1,400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,135,500.00	1,700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,613,000.00	4,800,000.00
2105	Нормативт зардал	69,640,800.00	95,257,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,869,200.00	63,647,800.00
210502	Хоол, хүнс	16,102,000.00	25,110,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,669,600.00	6,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,177,300.00	2,926,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,426,000.00	1,320,600.00
210604	Урсгал засвар	1,751,300.00	1,606,300.00
2107	Томилолт, зочны зардал	1980000.00	5741058.00
210702	Дотоод албан томилолт	1980000.00	5741058.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2143300.00	2407418.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	336000.00	505000.00
210803	Даатгалын үйлчилгээ	138600.00	133950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158400.00	120800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000.00	88000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800000.00	800000.00
210807	Газрын төлбөр	120800.00	114168.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100000.00	200000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	445500.00	445500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4250400.00	1779100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4250400.00	1779100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	700000.00	68848962.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	700000.00	68800000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700000.00	68800000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	48962.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		48962.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	284900.00	10788100.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	11073000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	11073000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	11073000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		11073000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-11073000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	284900.00	-284900.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		284900.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	284900.00	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	888221900.00	877780428.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	888221900.00	877780428.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	885721900.00	875280428.00

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	596283800.00	590140146.45
210101	Үндсэн цалин	371239300.00	373067820.00
210102	Нэмэгдэл	159026500.00	154498426.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10332100.00	6888000.00
210104	Урамшуулал	55685900.00	55685900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91725700.00	87476843.55
210201	Тэтгэврийн даатгал	67874200.00	66446788.32
210202	Тэтгэмжийн даатгал	5962900.00	5267809.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	4770300.00	4214227.25
210204	Ажилгүйдлийн даатгал	1192600.00	1391176.40
210205	Эрүүл мэндийн даатгал	11925700.00	10156841.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31129300.00	31129300.00
210301	Гэрэл, цахилгаан	5977200.00	5568700.00
210302	Түлш, халаалт	25152100.00	25560600.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52900000.00	52899920.00
210401	Бичиг хэрэг	4200000.00	4200000.00
210402	Тээвэр, шатахуун	4100000.00	40999920.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1200000.00	1200000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1700000.00	1700000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4800000.00	4800000.00
2105	Нормативт зардал	91947800.00	91947800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60447800.00	60447800.00
210502	Хоол, хүнс	2500000.00	2500000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6500000.00	6500000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11984900.00	11984900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10378600.00	10378600.00
210604	Урсгал засвар	1606300.00	1606300.00
2107	Томилолт, зочны зардал	3500000.00	3500000.00
210702	Дотоод албан томилолт	3500000.00	3500000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2456300.00	2407418.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	505000.00	505000.00
210803	Даатгалын үйлчилгээ	138600.00	133950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158400.00	120800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88000.00	88000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800000.00	800000.00
210807	Газрын төлбөр	120800.00	114168.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200000.00	200000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	445500.00	445500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3794100.00	3794100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3794100.00	3794100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2500000.00	2500000.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	2500000.00	2500000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2500000.00	2500000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	888221900.00	877829390.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	798829300.00	798829300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	798829300.00	798829300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32735600.00	32735600.00
132001	Орон нутгийн төсвөөс	32735600.00	32735600.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	56657000.00	46264490.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	56657000.00	46264490.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42.00	42.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	42.0	42.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	35.00	35.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	99971258.00
УРСГАЛ ЗАРДАЛ	99971258.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33671258.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23284318.00
Үндсэн цалин	23284318.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3000000.00
Тэтгэврийн даатгал	3000000.00
Хангамж, бараа материалын зардал	2120782.00
Бичиг хэрэг	250000.00
Тээвэр, шатахуун	1670782.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200000.00
Нормативт зардал	3310000.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3200000.00
Хоол, хүнс	110000.00
Томилолт, зочны зардал	1956158.00
Дотоод албан томилолт	1956158.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66300000.00

Бусад урсгал шилжүүлэг	66300000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	66300000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	99971258.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	99971258.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	99971258.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд авлага, өглөгийн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн №01 дүгээр албан бичгээр хуулийн хугацаанаас 23 хоног хоцроож 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго нь ард иргэдэд таатай орчинд түргэн шуурхай үйлчилж аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус Эрүүл мэндийн төвд 2021 онд дотоод аудитын шалгалт хийгдсэн ба бусад эрх бүхий байгууллагуудаас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 925.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 9.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 246.8 сая төгрөгөөр буюу 20.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	284.9	0.00	-284.9
Авлага	0.00	0.00	0.00
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	41894.3	50201.1	8306.8
Үндсэн хөрөнгө	1161844.3	1400637.3	238793.0
Нийт хөрөнгө	1204023.6	1450838.4	246814.8

Өр төлбөр	21035.2	23834.4	2799.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1182988.4	1427003.9	244015.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1204023.6	1450838.3	246814.7

Мөнгөн хөрөнгийн данс эхний үлдэгдэл 0.3 сая төгрөг ба оны эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 50.2 сая төгрөг болж 8.3 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 115.1 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй 13.3 сая төгрөгийн бараа материал хүлээн авч үйл ажиллагаандаа 120.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 6.2 сая төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1400.6 сая төгрөг болж 238.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 11.1 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 278.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй авч, аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 133 дугаар тогтоолын дагуу 107.7 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, үндсэн хөрөнгөнд 48.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 23.8 сая төгрөг болж 2.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагад төлөх өглөг, хоол, халаалт, эмийн өглөг байна.

Үүнээс эмийн өглөг 6.8 сая, халаалтын өглөг 9.8 сая, хоолны өглөг 5.8 сая төгрөг, байгууллагад төлөх өглөг 1.4 сая төгрөг байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан орон тооны хязгаарыг 5 хүнээр хэтрүүлэн өглөг үүсгэсэн зөрчилд албан шаардлага өгсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1427.0 сая төгрөг болж 244.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн 244.0 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1269.9 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 388.7 сая төгрөгөөр буюу 44.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, нэмэлт санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 100.6 сая төгрөгөөр буюу 10.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, Нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн бараа материалын зардал, норматив зардал, эд хогшил, урсгал зардал, томилот, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна. Байр ашиглахтай холбоотой зардал өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны анх батлагдсан төсөв 888.2 сая төгрөг, тодотгосон төсөв 888.2 сая төгрөг байна.

Нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд тусгай зориулалтын шилжүүлгээс 798.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 32.7 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 56.7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 888.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 877.8 сая төгрөгийг зарцуулж, төсвийн хэмнэлтээс 0.05 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 798.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 32.7 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 46.3 сая төгрөгийн санхүүжилт авч Эрүүл мэндийн даатгалын сангаас 10.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Нийт төсвийн 67.2 хувийг цалин, 10.0 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 3.5 хувийг тогтмол зардал, 6.0 хувийг хангамж бараа материалын зардал, 10.5 хувийг норматив зардал, 1.4 хувийг эд хогшил худалдан авах, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, 0.4 хувийг томилот, зочны зардал, 0.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, 0.4 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 0.3 хувийг урсгал шилжүүлэг зэрэг зардлууд эзэлж байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Эрүүл мэндийн яамнаас Ковид-19 цар тахлын санхүүжилтэд 42.1 сая төгрөг, Эрүүл мэндийн яамнаас нэг удаагийн тэтгэмж болон сорьц тээвэрлэх зардалд 57.8 сая төгрөгийн нийт 99.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авчээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 23.3 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 3.0 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 2.1 сая төгрөг, норматив зардалд 3.3 сая төгрөг, томилот, зочны 1.9 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг зардалд 66.3 сая төгрөг нийт 99.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар аргачлалын дагуу толилуулж, тодруулаагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй дараах байдал үүссэн болно. Нягтлан бодох бүртгэлийн заавал хөтлөх журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс бүртгэлийг санхүүгийн программаар бүрэн хөтөлж баримтжуулаагүйгээс тайлант хугацааны ажил гүйлгээ, дансны үлдэгдэлийг бүрэн тулгах боломжгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Б/31 тоот тушаалаар нягтлан бодогчийг ажлаас чөлөөлж, оронд нь шинээр нягтлан бодогч томилсон байна. Өмнөх нягтлан бодогч нь санхүүгийн баримт материалаа хүлээлгэж өгөөгүйгээс санхүүгийн тайлан гаргахад хүндрэл учирсан байна.

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2021 онд нийт 977,800.6 мянган төгрөгийн 145 мэдээллийг ил тод байршуулахаас 58 мэдээллийг хугацаандаа байршуулж, 27 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй 31.9 сая төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй, 87 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 60.0 хувьтай, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд аудитаар шилэн данстай холбоотой 1 зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021.11.29-ний 64 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Давтан шалгаж үзэхэд 58 мэдээллийг хугацаандаа байршуулж, 27 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс 31.9 сая төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй, 87 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 60.0 хувьтай, өмнөх оны аудитаар шилэн дансны 63 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг давтан гаргаж, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар эрсдэлтэй данс, ажил гүйлгээнүүдэд түүвэр сорил хэрэгжүүлсэн тул төсвийн зарцуулалт, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай. Дараагийн аудитаар нягтлан болох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудалд анхаарал хандуулах хэрэгтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 524.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 524.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

1.Аудитаар 524.3 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

Үүнд:

1.Санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн дансанд 1,579.8 сая төгрөгийн, бараа материалын дансанд 50.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийхдээ 248.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу тоолсон, тооллогын бүртгэлийн дүнгүүд нь зөрүүтэй, 50.2 сая төгрөгийн бараа материалын тооллого хийгдээгүй, тооллогын дүнг санхүүгийн тайлан дахь хөрөнгийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулах боломжгүй, өмнөх оны аудитаар бараа материалын үлдэгдлийн тооллого хийгдээгүй, үндсэн хөрөнгийн тооллогыг дутуу хийсэн зөрчлийг давтан гаргаж, өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

2.Нягтлан бодох бүртгэлийн заавал хөтлөх журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс бүртгэлийг хөтлөөгүй, санхүүгийн программыг бүрэн ашиглаагүй, санхүүгийн тайлангийн тодруулга, төсвийн гүйцэтгэлийн танилцуулгыг зааврын дагуу бэлтгэж ирүүлээгүй, тайлант онд гэрэл цахилгаан, шуудан холбоо, интернэт, бичиг хэрэг, тээвэр шатахуун, эм, хоол хүнс, түлш халаалт, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусад урсгал шилжүүлгийн зардлын тооцоогоор гарсан нийт 176.6 сая төгрөгийн зарлагын гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

3.Санхүүгийн тайлангаар 23.8 сая төгрөгийн өглөгтэй гарснаар тайлагнасан боловч үлдэгдэлийг бүрэн баталгаажуулаагүй байна. Төсвийн шууд захирагчийн 2021 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанаас 23 хоног хоцроож 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг дахин хянаж үлдэгдлийг баталгаажуулах, өглөгийг харилцагч байгууллага бүрээр тооцоо нийлэх, Нягтлан бодох бүртгэлийн заавал хөтлөх журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс бүртгэлийг санхүүгийн программаар бүрэн хөтөлж баримтжуулах, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгаж дахин давтан гаргахгүй албан шаардлага өгөв.

2.Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2021 онд нийт 977,800.6 мянган төгрөгийн 145 мэдээллийг ил тод байршуулахаас 58 мэдээллийг хугацаандаа байршуулж, 27 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс 31.9 сая төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй, 87 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, шилэн

дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 60.0 хувьтай, өмнөх оны аудитаар шилэн дансны 63 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг давтан гаргаж, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 5.1.4-т “мэдээллийг тогтмол шинэчилж байх”, 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллүүдийг хугацаанд нь бүрэн оруулах, зөрчлийг арилгаж, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дэлүүн сумын Эрүүл мэндийн төв	2	524.3					2	524.3		
Нийт дүн		2	524.3					2	524.3		